



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/258

Арвайхээр

**Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад
шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нэр бүхий газар эзэмшигчдийн гаргасан хүсэлтийн дагуу Арвайхээр сумын инженерийн шугам сүлжээ бүхий газарт байрлах 6 нэгж талбарын газар эзэмшигч иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшил газрыг зориулалтын дагуу хавсралтад зааснаар газар эзэмших эрхийг тус тус шилжүүлсүгэй.

2.Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны А/476 дугаар захирамжийн Д.Бүзмаатай холбогдох заалт, 2019 оны А/615 дугаар захирамжийн хавсралтын Р.Долгорсүрэнтэй холбогдох заалт, 2020 оны А/396 дугаар захирамжийн хавсралтын Н.Мягмаржавтай холбогдох заалт, 2011 оны 297 дугаар захирамж, 2016 оны А/311 дүгээр захирамжийн хавсралтын С.Батбаяртай холбогдох заалт, 2008 оны 144 дүгээр захирамжийн Ж.Гансүхтэй холбогдох заалт, 2015 оны А/176 захирамжийн Гэрийн илч газ ХХК-тай холбогдох заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100554

D:My Doc. Zahiramj. Zasag darga